

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ХЭНТИЙ АЙМГИЙН “ХЭНТИЙ УС” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН
ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: ХЭА-2026/014/НА-СТА-ОНӨҮГ

Чингис хот

2026 он

Цахим хаяг: www.audit.mn

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим
хаяг: khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг:
oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705
Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.13 № 467

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Хэнтий-Ус” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Хэнтий-Ус” ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 10,783.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагаандаа 10,868.9 сая төгрөгийг зарцуулж, 85.1 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Тайлант онд урт хугацаат зээлийн эргэн төлөлт, хүүгийн зардалд 1,000.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс төлсөн байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр Бэрх хотын дулааны станцын барилга байгууламж, машин, тоног төхөөрөмж 15,696,2 сая төгрөг, аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 29,804.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирснийг орлогоор бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 1,983.9 сая төгрөгийн 6 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийж, 33.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бусад асуудлын хэсэг

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 26 мэдээллийг 94.4 хувьтай мэдээлсэн буюу худалдан авах ажиллагааны тайлан, төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, дараа жилийн зорилтот түвшин, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 390.5 сая төгрөгийн 13 мөнгөн гүйлгээ, хандив, тусламжийн зарцуулалтын тайлан, аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан хэсэгт 163,962.4 мянган төгрөгийн 4 аудитын шийдвэрийг мэдээлээгүй зөрчлийг цаашид давтахгүй ажиллах нь зүйтэй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН.
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		2025 оны 1 сарын 1	2025 оны 12 сарын 31
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	50,197,297.60	25,721,872.03
1.1.02	Дансны авлага	237,247,927.84	353,948,079.28
1.1.04	Бусад авлага	13,891,922.70	11,070,977.28
1.1.06	Бараа материал	302,408,190.50	419,509,959.46
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,132,987.63	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	604,878,326.27	810,250,888.05
1.2.01	Үндсэн хөрөнгө	35,071,405,980.04	79,653,174,425.70
1.02.02	Биет бус хөрөнгө	380,000.00	380,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	35,071,785,980.04	79,653,554,425.70
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	35,676,664,306.31	80,463,805,313.75
2.1.1.01	Дансны өглөг	485,313,759.29	642,664,433.52
2.1.1.03	Татварын өр	438,803,201.82	557,152,387.99
2.1.1.04	НДШ - ийн өглөг	-	43,982,970.95
2.1.1.05	Богино хугацаат зээл	221,804,580.00	163,137,180.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	12,565,795,045.52	57,304,232,039.45
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	235,127,266.29	271,114,278.40
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	13,946,843,852.92	58,982,283,290.31
2.1.2.01	Урт хугацаат зээл	754,997,774.27	275,000,000.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	11,666,053,183.31	11,912,800,384.54
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	12,421,050,957.58	12,187,800,384.54
2.2	Өр төлбөрийн нийт дүн	26,367,894,810.50	71,170,083,674.85
2.3.01	Өмч: - төрийн	8,644,662,384.67	8,644,662,384.67
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,675,409,524.20	1,675,409,524.20
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	364,616,130.00	364,616,130.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,375,918,543.06)	(1,390,966,399.97)
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	-	(85,077,876.21)
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	(1,375,918,543.06)	(1,305,888,523.76)
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,308,769,495.81	9,293,721,638.90
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	35,676,664,306.31	80,463,805,313.75

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	7,758,276,407.29	7,969,965,013.35
02	Борлуулалтын өртөг	8,593,245,093.40	9,727,573,040.72
03	Нийт ашиг(алдагдал)	-834,968,686.11	-1,757,608,027.37
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	0.00	0.00
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	712,880,000.00	1,100,000,000.00
08.1	Орлогын дүн	712,880,000.00	1,100,000,000.00
09	Борлуулалт, маркетингийн зардал	26,842,407.40	23,564,514.52
10	Ерөнхий ба удирдлагын зардал	487,818,099.69	532,271,342.60
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	0.00
12.1	Зардлын дүн	514,660,507.09	555,835,857.12
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	-466,749,426.96
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	700,437,485.53	1,595,115,435.24
17.1	Олз, гарзын дүн	700,437,485.53	1,128,366,008.28
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	63,688,292.33	-85,077,876.21
19	Орлогын татварын зардал	0.00	0.00
20	Татварын дараах ашиг (алдагдал)	63,688,292.33	-85,077,876.21
21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	63,688,292.33	-85,077,876.21
	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,320,071,908.87	364,616,130.00	-1,439,606,835.39	9,245,081,203.48
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	63,688,292.33	63,688,292.33
05	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00
06	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	10,320,071,908.87	364,616,130.00	-1,375,918,543.06	9,308,769,495.81
07	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00
08	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	70,030,019.30	70,030,019.30
09	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	-85,077,876.21	-85,077,876.21
10	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
11	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	10,320,071,908.87	364,616,130.00	-1,390,966,399.97	9,293,721,638.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	8,961,192,783.66	9,701,666,998.17
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	8,157,632,100.66	8,386,070,832.64
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	712,880,000.00	1,125,000,000.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	90,680,683.00	190,596,165.53
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	8,953,968,610.74	9,642,600,085.97
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,565,357,469.73	3,577,415,242.15
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	807,950,151.75	1,016,686,665.69
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,774,012,011.55	1,575,123,298.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	994,203,773.19	984,538,681.13
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,610,949,516.39	1,018,121,654.15
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	37,627,927.82	29,599,715.35
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	626,860,197.42	918,158,270.46
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	3,990,000.00	1,430,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	533,017,562.89	521,526,559.04
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	7,224,172.92	59,066,912.20
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	338,532.17	125,062.23
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	338,532.17	125,062.23
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	79,245,925.00	25,000,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	79,245,925.00	25,000,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.2.6	Бусад	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-78,907,392.83	-24,874,937.77
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Бусад	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	71,528,420.00	58,667,400.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	71,528,420.00	58,667,400.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Бусад	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-71,528,420.00	-58,667,400.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-143,211,639.91	-24,475,425.57
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	193,408,937.51	50,197,297.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	50,197,297.60	25,721,872.03

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,983,933.1 мянган төгрөгийн алдаа илэрснийг санхүүгийн тайланд залруулга хийлээ. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-аас төлсөн урт хугацаат зээлийн хүүд 300,000.0 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлтөд 700,000.0 мянган төгрөг, нийт 1,000,000.0 мянган төгрөгийг, зээлийн ханшны зөрүүнээс үүссэн гарз 466,748.4 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй орхигдуулсан;
- Урьдчилж орсон орлогын хорогдуулалтыг 215,131.7 мянган төгрөгөөр алдаатай илэрхийлсэн;
- Санхүүгийн тайланд НӨАТ-ын өглөгийг татварын системээс 176,680.5 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийн эхний үлдэгдлийг дэлгэрэнгүй тайлангаас 65,801.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Өртөгөө бүрэн нөхөж эдэгдлийн хугацаа дууссан боловч ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг 32,030.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож орлогоор бүртгэхдээ дахин үнэлгээний дансыг нэмэгдүүлж нягтлан бодох бүртгэлийг алдаатай хөтөлсөн;
- Санхүүгийн тайланд авлага өглөгийн дансыг тохируулаагүйгээс өглөгийн дансыг 27,519.4 мянган төгрөгөөр хасах тэмдэгтай илэрхийлсэн;

Аудитаар нийт 33,798.3 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

3.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй байна.

3.2 Албан шаардлага

- Малын төлийн орлого, нас дэвшилтийн орлого, зарлагын бүртгэл хөтлөөгүй, 33.8 сая төгрөгийн үлдэгдлийг тоолж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, бэлэн бүтээгдэхүүн бусад материалын үлдэгдлийг тоолсон боловч эд хариуцагчтай тооцоо бодон үлдэгдлийг актаар баталгаажуулж, баримтжуулаагүй байна.

3.3 Зөвлөмж

Зөвлөмж хүргүүлээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруула агүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урт хуугацаат зээл	1	1,466,749.4	1	1,466,749.4			1	1,466,749.4				
Урьдчилж орсон орлого	1	215,131.7	1	215,131.7			1	215,131.7				
Өр төлбөр	2	204,220.3	1	176,680.5	1	27,539.7	2	204,220.3				
Үндсэн хөрөнгө	2	97,831.8			2	97,831.8	2	97,831.8				
Дүн	6	1,983,933.1	3	1,858,561.6	3	125,371.5	6	1,983,933.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Бараа материалын тооллого	1	33,798.3			1	33,798.3							
Дүн	1	33,798.3			1	33,798.3							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зөрчил илрээгүй								
Дүн								
Нийт дүн								



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 03 сарын 13

Дугаар 236-А 2370449

Чингис хот

ХЭА - 2026/014/НА-СТА-ОНОВГ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн "Хэнтий ус"ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд малын төлийн орлого, нас дэвшилт, зарлагын бүртгэл хөтлөөгүй, 33,798,346.00 /гучин гурван сая долоон зуун ерин найман мянга гурван зуун дөчин зургаа/ төгрөгийн үлдэгдлийг тоолж, тооцоо бодсон актаар баталгаажуулаагүй, бэлэн бүтээгдэхүүн бусад материалын үлдэгдлийг тоолсон боловч эд хариуцагчтай тооцоо бодон үлдэгдлийг актаар баталгаажуулж, баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ыг дагаж мөрдөнө", 12 дугаар зүйлийн 12.1-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 12.2-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. 14 дүгээр зүйлийн 14.3-д "Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ", 14.3.1-д "анхан шатны баримт бүрдүүлэх; 14.3.2. журналд бичих; 14.3.3. дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх; 14.3.4. ажил, гүйлгээний мэдээ гаргах; 14.3.5. санхүүгийн тайлан гаргах", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1 "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.2-д "хөрөнгийн тооллогыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу хийгээгүй, баримтжуулаагүй, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материалын тооллогыг чанаргүй гүйцэтгэдэг, нягтлан бодох бүртгэлийг стандартын дагуу хөтөлдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг гүйцэтгэх зарирал Д.Хүрэлбаатар, нягтлан бодогч Б.Ичинхорлоо нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР

Ж.ГАНБААТАР
Х.ЕРКЕГҮЛ